



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар A/491

Хэрлэн сум

Төсөл, арга хэмжээний  
хэрэгжилтийг хангуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоногийн температур 0°C хэмээс доошилж хүйтэрч байгаатай холбогдуулан барилга угсралт, их засварын ажлын чанарт нөлөөлж болзошгүй эрсдэлийг тооцон барилгын ажлын техник хяналтыг сайжруулах, зөвлөмж, шаардлагыг тухай бүр барилгын ажлын гүйцэтгэгч байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулах, гэрээний хугацаанд барилгын ажлыг бүрэн гүйцэтгүүлэх арга хэмжээг зохион байгуулж, ажил гүйцэтгэх графикаас хоцрогдолтой үргэлжилж байгаа барилгын ажлын графикийг шинэчлэн баталж, ажиллах хүчийг нэмэгдүүлэх, шаардлагатай бусад ажлыг зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Д.Баярхүү)-д үүрэг болгосугай.

2.Зураг төсөл боловсруулах ажлын зураг төсөл боловсруулах даалгавар, архитектур төлөвлөлтийн даалгаврыг шуурхай боловсруулан батлах, зураг төсөл боловсруулах явцад оролцогч талуудын уялдаа холбоог хангаж, мэргэжил, арга зүйн зөвлөмжийг тухай бүрд өгч, шаардлагатай тохиолдолд оролцогч талуудыг байлцуулан талууд тус бүрээс зураг төсөл боловсруулахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг нэгтгэж зураг төслийн зохиогч байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Ерөнхий архитектор (Ш.Ариунболов)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

